

БАТЛАВ  
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Т.НЯМ-ОЧИР

2023 оны 10 сарын 18 ны өдөр

## **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД “PEARSON”, “EDUTEN” ЦАХИМ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАРААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

### ***Нэг. Үндэслэл***

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай” 372 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, төлөвлөгөө батлах тухай” А/353 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Сургалтын цахим систем нэвтрүүлэх, зардал батлах тухай” А/312 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилээс ЕБС-ийн 3-4 дүгээр ангид Эдүтэн цахим систем, 5-6 дугаар ангид олон улсын англи хэлний Пийрсон хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад 2023-2024 оны хичээлийн жилд баримтлах чиглэлийн 1.3-т Ерөнхий боловсролын сургуулийн 3-4 дүгээр ангид математикийн хичээлийн долоо хоногийн нэг цагийг "Eduten" цахим системийг ашиглан зохион байгуулах; 1.4-т Ерөнхий боловсролын сургуулийн 5-6 дугаар ангийн англи хэлний хичээлийг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт цагт цахим технологид суурилсан "Pearson" англи хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тус тус тусгасан. Иймд тус үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх сургалтын орчны бэлэн байдал, цахим системийн бүртгэл, ашиглалт, сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт зэрэг хэрэгжилтийн гарааны нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ үүсэж байна.

### ***Хоёр. Зорилго***

Ерөнхий боловсролын сургуулиудад "Eduten", "Pearson" хөтөлбөрийн хэрэгжилтийн гарааны явцтай танилцах, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаашид хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж боловсруулах, танилцуулах

### ***Гурав. Хугацаа, зохион байгуулалт***

- Нийслэлд 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 10 дугаар 20-ны өдрүүдэд Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд, боловсролын салбарын хяналт хариуцсан байцаагчид

- Орон нутагт 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд БШУГ-ын мэргэжилтнүүд, боловсролын салбарын хяналт хариуцсан байцаагчид хамтран зохион байгуулна.

#### **Дөрөв. Хамрах хүрээ**

- 21 аймаг, нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд

#### **Тав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай тушаал, шийдвэрүүдийн биелэлт, нөхөн хангалтын зардлын зарцуулалт, хэрэгжилтийн явцтай танилцах чиглэлээр сургуулийн удирдлагатай ярилцлага хийх /Хавсралт-1. Сургуулийн удирдлагаас авах асуулга/
- Математикийн "Eduten" цахим системийг ашиглах сургууль, дэмжигч багш, ангийн бүртгэл, хичээлийн явц-системтэй тулгалт хийж, сургалтын менежертэй ярилцлага хийх, шалтгааныг илрүүлэх /Хавсралт-2. Хичээл ажиглалт, ярилцлагын хуудас/
- Англи хэлний "Pearson" хөтөлбөрийн хичээлийн бэлтгэл хангагдсан байдал болон хичээл сургалтын хэрэгжилтийн явцтай танилцах, хичээлд ажиглалт хийх, сургалтын менежертэй ярилцах – /Хавсралт-3. Хичээл ажиглалт, ярилцлагын хуудас/
- "Eduten", "Pearson" хөтөлбөрийг хэрэгжүүлэх цахим, танхим орчин бүрдсэн эсэх (интернэт сүлжээ, тоног төхөөрөмж, таблет, зөөврийн ба суурин компьютерийн хүртээмж...) талаар судалгаа авах: Google form-ийн холбоос: <https://forms.gle/6WoWhN2hMMgS9wKV7>

#### **Зургаа. Хүлээгдэж буй үр дүн**

- "Eduten", "Pearson" хөтөлбөрийн хэрэгжилтийг гарааны явцтай танилцан тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх
- Гарааны судалгааны үр дүнгийн тайланг нэгтгэн зөвлөмж гаргах